

“Мон- Гео” ХК-ийн 2017 оны үйл ажиллагааны тайлан ,

дэвшүүлэх зорилтуудын талаар

Тус компани нь тайлант хугацаанд компанийн тухай хууль , компанийн дүрэм , өөрийн дотоод журам , СЗХ –ны баталсан журам өмнө оны Хувь нийлүүлэгчдийн хурлын болон ТУЗ-ийн хурлын шийдвэрүүдийг биелүүлэн ажиллах чиглэлийг баримтлан үйл ажиллагаагаа явуулж дуусгасан болно.

“Монгое” ХК “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХКомпанитай үнэт цаасны хадгаламжийн болон үнэт цаастай холбогдолтой төлбөр тооцоо гүйцэтгэх гэрээг хугацаанд нь байгуулан төлөх ёстой төлбөрийг барагдуулан хамтран ажиллаж байгаа билээ. Мөн Санхүүгийн Зохицуулах Хороо, Хөрөнгийн Биржтэй хамтран ажиллаж байна .

Манай компани одоогийн байдлаар өөрийн эзэмшилийн 12-272 м2 талбай бүхий өрөөнүүдийг үйлдвэрлэл, оффисийн зориулалтаар аж ахуй нэгж болон хувь хүнд түрэслүүлэн түрээсийн үйл ажиллагаа явуулж байгаа юм.

“Монгое” ХК 18 хүний орон тоотой 2017 онд 7 хүний орон тоогоор ажиллалаа. Үнд : үндсэн ажилтан - 4 хүн , гэрээт ажиллагсад – 3 хүн ,

Компанийн ажиллагсад сар бүр ажлаа төлөвлөн , бүх ажиллагсдын хурлаар биелэлтийг дүгнэн ажилладаг. Үндсэн 18 орон тооны 11 нь геологийн хайгууль , зургийн чиглэлийн мэргэжилтэй , компани үндсэн үйл ажиллагаагаараа ажиллах мөчийг хүлээж байгаа мэргэжилтнүүд юм.

Сар бүр байгууллагын санхүүд төвлөрдөг түрээсийн орлогыг ажиллагсдын цалин , бүх төрлийн татвар үйл ажиллагаандаа хэрэглэж буй дулаан , цахилгаан , усны төлбөрт боломжоор нь хуваарилан зарцуулж байгаа болно.

Гэвч тус компани үндсэн” барилгын зураг төсөл , геодези зураг зүйн үйлдвэрлэл , үйлчилгээ эрхлэх , кадастрын зураглал, геологийн судалгаа явуулах , гадаад худалдаа , худалдааны зуучлал”-ын чиглэлээрээ үйл ажиллагаа явуулахгүй байгаа учраас алдагдалтай, байгууллагуудад өглөгтэй байгаад байгаа юм.

Тайлант хугацаанд түрээсийн үйл ажиллагаанаас 75.631.249 төгрөгийн орлого төвлөрүүлснээс зээл зээлийн хүү бүх төрлийн татвар хэрэглээний цахилгаан, дулаан ,усны төлбөр, байгууллагын ажиллагсдын цалин болон бусад үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг төлөх ажлыг гүйцэтгэсэн байна .

Гэвч оны эцэст татварт 5881.621 төгрөгийн өглөгтэй гарсан нь өнгөрсөн онтой харьцуулахад ахицтай гарсан байна .

2017 онд компани санхүү татварын тайлангуудыг хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагуудад тайлagnаж жилийн эцэст / Б ЭНД С Аудит ХХК / Аудитын байгууллагаар тайлангаа хянуулсан.

Өнгөрсөн оны хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлаас гаргасан шийдвэрүүдийг зохих түвшинд биелүүлэн ажилласан бөгөөд 2 шийдвэрийг эдийн засгийн хүндрэлтэй байдал, боломжит нөхцөл бүрдээгүй учраас биелүүлээгүй байна .

Тус компанийн байранд одоогийн байдлаар 17,3 – 54 м<sup>2</sup> талбай бүхий оффисийн зориулалтаар ашиглах 7 өрөө , мөн үйлдвэрлэл болон бусад чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж болохуйц 64-72 м<sup>2</sup>, 3 өрөө сул, ашиглалтгүй байна.

Бид түрээсийн үйл ажиллагаа явуулж байгаа болохоор эдгээр сул байгаа өрөөнүүдийг бусад байгууллага хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа иргэдэд түрээслүүлж чадвал сар бүр зардлаа нөхөөд ашигтай биш гэхэд алдагдал багатай ажиллаж болох юм.

#### Цаашдын зорилтын хувьд :

1. Компанийн өмнө нь хийж гүйцэтгэсэн / Янгирт Улаан-50 / , / Энгэр- Шанд- 50 / / Улаанбаатар барилга/ гэх мэт төслийг хэрэгжүүлэх хугацааг холбогдох байгууллагаудаас асууж судлах, тендер зарлагдах үед боломжоороо оролцох ,

2. Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх , үнэт цаасны зах зээлийг судлах дахин хувьцаа гаргах замаар санхүүгийн чадамжийг дээшлүүлэх арга замыг судлах, судалгааг хэрэгжүүлэх арга хэмжээ авах ,

3. Гадаад харилцааг судлах, гадны түншүүдтэй хамтран ажиллах боломж нөхцлийг эрэлхийлэх ,

4. Хөрөнгө оруулалт болон бусад нөхцөл байдлыг судлан хөөцөлдөж компанийн бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх тал дээр дорвитой арга хэмжээ авахад компанийн нийт ажиллагсад ,ГУЗ-ийн дарга ,гишүүд идэвхитэй оролцох шаардлагатай байна.

Компани үндсэн үйл ажиллагааныхаа чиглэлээр ажиллах бүрэн боломжтой юм . Эдийн засаг санхүүгийн чадамж боломжгүй байдлаас үүдэн энэ боломжоо ашиглаж чадахгүй байгаа билээ .

Хурлаас гарах санал, тогтоол шийдвэрүүдийг хүндэтгэн хүлээн авч тус шийдвэрт компанийн үйл ажиллагааг чиглүүлэн ажиллах болно .

“Монгэо” ХК-ийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар улсын чанартай зохион байгуулагдах ажилд идэвхитэй оролцох тухай

“Монгэо” ХК 1996 онд байгуулагдсан . Байгуулагдсан цагаасаа эхлэн барилгын зураг төсөл геологийн зураг зүйн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх кадастрын зураглал хийх үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэлээр геологийн судалгаа явуулах гадаад худалдаа , худалдааны зуучлал зочид буудал зоогийн газар гэсэн туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Компани 2004-2009 онуудад Янгирт Улааны талбайн 1:50000 масштаб геологийн зураглал ерөнхий эрлийн ажил ЯУ50 гэсэн төслийг амжилттай хийж гүйцэтгэжээ. Мөн 2006 -2009 онуудад Дундговь аймгийн Эрдэнэдалай Адаацаг сумдын нутаг дэвсгэрийг хамарсан 2140,82 Км<sup>2</sup> талбайг 1:50000 масштабтай геологийн зураглал , ерөнхий эрлийн ажлыг төсөлд заасан аргачлалын дагуу гүйцэтгэж төслийг амжилттай хэрэгжүүлж дуусгасан болно.

Улсын төсвийн хөрөнгөөр 2006-2007 ондуудад “Монгэо” ХК Дундговь аймгийн эрдэнэдалай , төв аймгий Баян сумын нутагт дээвэр зам талбай болон ирцийн хөвөнгийн түүхий эдийн зориулалтаар хэрэглэх занар , алевролит, элсэн чулуу хүрмэн чулууны эрэл, эрэл үнэлгээний ажил УБ барилга 2006 төслийг амжилттай гүйцэтгэсэн билээ.

Иймээс ажиллах хүч компанийн эрхлэх ажлын чиглэлд тулгуурлан улсын чанартай зохион байгуулагдах ажилд компани биечлэн оролцох бүрэн эрхтэй. Түүнчлэн нэн шаардлагатай гэж үзэж байна .

Талбайн 1: 50000 масштабын геологийн зураглал ерөхий эрлий ажлын тендер зарлагдсан тохиолдолд компани заавал оролцох естий.

Янгирт Улаан 50 төслийн ажилд 2008 онд тендер зарлагдсан боловч ерөнхийлөгч хориг тавьсан. Гэвч энэ хориг тавигдаж үйл ажиллагаа үргэлжлэн явагдах байхаа.

Мөн 2006 – 2009 онуудад амжилттай хийж дуусгасан дээрхи ажлуудад тендер зарлагдвал тооцоо судалгааг чанартай хийж “Монгэо” ХК албан ёсоор оролцох болно.

Монгэо ХК

2018.04.01